

ХӨДӨЛМӨРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ ЮРАГИЙН ОТГОНБИЛЭГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ “Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, халамжийн мөнгөн дүнг нэмэгдүүлэх, орчин үеийн стандартыг нэвтрүүлэх зорилгоор эрх зүйн шинэчлэл хийж, хэрэгжүүлнэ.”							
1.	Арга хэмжээ 1.1. Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлоготой уялдуулан Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.	100%	30%	70%	Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандах судалгааг шинэчлэн, хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг сайжруулан боловсруулав. Нийгмийн халамжийн тухай хуулийн үзэл баримтлалын төслийг ТУСС судалгааны байгууллагын саналыг үндэслэн дахин сайжруулж, 2024.11.11-ний өдрийн 01/1195 дугаар албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлэв. Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2024.10.14-ний өдөр Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдэд, үзэл баримтлалын төслийг УИХ-ын даргын зөвлөлд 2024.11.22-ны өдөр тус тус танилцуулав.	07-12	

					УИХ-ын даргын тогтоолоор УИХ-ын гишүүн Б.Жаргалангаар ахлуулсан “Нийгмийн халамжийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах” ажлын хэсэгт танилцуулга, тоон мэдээлэл бэлтгэж хүргүүлсэн. Мөн НББХороо болон Б.Жаргалан гишүүнээр ахлуулсан ажлын хэсэгт Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийг танилцуулсан. Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэг, судалгааны дэд ажлын хэсгийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024.11.27-ны А/58 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуультай холбогдох хэсгийг танилцууллаа. Хуулийн төслийг бусад улсын хууль, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжтой уялдуулан судалж боловсруулав.		
2.	Арга хэмжээ 1.2. “Нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах, цахимжуулах төлөвлөгөө”-ний хүрээнд холбогдох журмуудыг шинэчлэн боловсруулж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэнэ.	100%	0%	100%	✓ Засгийн газрын 2021 оны 362 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам”-ыг хэрэгжүүлэх явцад гарсан тодорхой тусгах шаардлагатай зарим асуудал, үйлчилгээг хүргэх процессыг хялбарчлах хэрэгцээ шаардлагад үндэслэн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт	10-12	

	- Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам - Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам - Насны хишгийн хэмжээ тогтоох тогтоолын өөрчлөлт			оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулав. Журамд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс санал авч тусган, ГБХНХЯ-ны холбогдох газар, хэлтсийн дарга нараар хянуулан Засгийн газрын гишүүдээс санал авахаар 2024.12.09-ний өдрийн 01/1552 дугаар албан бичгээр яамдад хүргүүлэв. Журмын төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэний байнгын асаргаа шаардлагатай болохыг ЭММЗ-өөр тодорхойлуулдаг болох, нэг гэр бүлийн бүтэн өнчин хүүхдийг гэр бүлдээ авч асарч байгаа тохиолдолд хүүхдийн тоо хязгаарлахгүй байх, төрөлжсөн асрамжийн газарт асруулж байгаа тэжээгч нас барсан хүүхдийг халамжийн тэтгэвэрт хамруулах, тэтгэврийг банканд хадгалах, насанд хүрэх эсхүл асрамжаас гарахад тэтгэврийн мөнгийг хүлээлгэн өгөх, хяналт тавих зохицуулалтыг тусгах, тэтгэвэр, тэтгэмжийн мөнгийг барьцаалж зээл авах, олгох, банкны зээлд суутгахыг хориглох, хяналт, шинжилгээ, үнэлгээ, хариуцлагын заалт болон иргэдийн санал гомдлыг нээлттэй хүлээн авч шийдвэрлэх зэрэг зохицуулалтыг нэмж тусгасан. Мөн энэ журамд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Засгийн газрын 2023 оны “Дүрэм батлах тухай” 448 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-д		
--	---	--	--	---	--	--

нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулав.

✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлтийн үйлчилгээг цахим системд шилжүүлсэн, тусламж, хөнгөлөлт олгох процессыг иргэдэд хүндрэл, чирэгдэлгүй болгох, хэрэгжилтийн явцад тулгамдаж буй зарим асуудлыг шийдвэрлэх зорилгоор Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөнгөлөлт, тусламж үзүүлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж, 2024.12.09-ний өдрийн 01/1551 дугаар албан бичгээр яамдаас санал авахаар хүргүүлж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган ажилласан.

✓ Ахмад настны тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр ахмад настанд олгох насны хишгийн хэмжээг Засгийн газар батлахаар заасан бөгөөд уг хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр заасан.

Иймд Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн “Тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох тухай” 136 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах, насны хишгийн хэмжээг тогтоолд оруулахаар “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан танилцуулгын хамт 2024.12.09-ний өдрийн 01/1553 дугаар албан бичгээр санал авахаар яамдад хүргүүлсэн.

3.	Арга хэмжээ 1.3. Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулж батлуулах, хуулийг сурталчлах сургалтууд зохион байгуулж оролцох	100%	0%	100%	Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагалдах 9 хуулийн төслийн хамт боловсруулан 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хурлаар батлуулсан. Хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд ТББ-ууд, Ахмадын холбоо, салбар хороод болон ахмад настуудад хуулийг танилцуулж, холбогдох журмын төслүүдэд санал авч ажиллалаа. Монголын Ахмадын холбоо, яам хамтран Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэхтэй холбогдуулан орон нутгийн төрийн захиргааны байгууллага, ахмадын байгууллагын удирдлагуудад зориулсан хууль журмын талаар танилцуулах бүсийн сургалтад тавих мэдээллийг бэлтгэн сургагч багш нарт танилцуулав. Ахмад настны тухай хуулийг сурталчлан таниулах нөлөөллийн ажлыг зохион байгуулах хүрээнд яам болон Монголын Ахмадын холбоо хамтран зохион байгуулсан Орон нутгийн бүсийн сургалтаар Хэнтий, Орхон аймагт ажиллалаа. Сургалтад Хэнтий, Дорнод, Сүхбаатар болон Хөвсгөл, Булган, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, аймаг, сумдын Ахмадын хороо, зөвлөлийн идэвхтэн сонгуультаан нийт 80 оролцогчдод 2025 оны 01 дүгээр сарын	07-12	
----	--	------	----	------	---	-------	--

					01-нээс хэрэгжих Ахмад настны тухай хууль, хуульд орсон гол өөрчлөлт, хуулийг дагаж гарах Засгийн газар болон сайдын тушаалаар батлагдах журмуудын төслийг танилцуулж, саналыг авав. Монгол Улсын Хөдөлмөрийн баатруудын холбооноос ирүүлсэн хүсэлтийг судлан Улсын баатар Хөдөлмөрийн баатар ахмад настнуудын нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сайжруулах асуудлаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Ерөнхийлөгчийн Зарлигийн төсөл, танилцуулгын төсөл боловсруулав.		
4.	Арга хэмжээ 1.4. Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын тогтоолоор батлах журмуудыг боловсруулж, батлуулна.	100%	0%	100%	Ахмад настны тухай хуульд 2024 онд орсон нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор батлагдсан Насны хишиг олгох журмыг шинэчлэх, Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 197 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлт олгох журмыг шинэчлэх, мөн тогтоолын 2, 3 дугаар хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах, “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээг шинээр үзүүлэх, барилга байгууламж барих аж ахуйн нэгж, байгууллагад төрөөс нэг удаагийн дэмжлэг үзүүлэх журам”-ын төслийг тус тус боловсруулж, “Журам батлах, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, Засгийн газрын гишүүдээс	10-12	

					санал авахаар 2024.09.27-ны өдрийн албан бичгээр яамдад хүргүүлсэн. ✓ Ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлт олгох журмын төсөл ✓ Насны хишиг олгох журмын төсөл ✓ Төрөлжсөн асрамжийн үйлчилгээг шинээр үзүүлэх, барилга байгууламж барих аж ахуйн нэгж, байгууллагад төрөөс нэг удаагийн дэмжлэг үзүүлэх журмын төсөл ✓ “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой тогтоолын төсөл ✓ “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой тогтоолын төсөл		
5.	Арга хэмжээ 1.5. Асаргааны хувилбарт үйлчилгээ, идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээг бий болгох зорилгоор ГБХНХ-ын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалыг боловсруулна. - Ахмад настанд цогц үнэлгээ хийх, үйлчилгээ үзүүлэх журам - Мэргэжлийн удирдлагын заавар - Иргэн, аж ахуйн нэгж, ТББ-ыг сонгон шалгаруулах журам	100%	40%	60%	Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1-д ахмад настанд цогц үнэлгээ хийх, цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах, үйлчилгээ үзүүлэх иргэн аж ахуйн нэгж байгууллагын сонгон шалгаруулах журмыг нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталж, хэрэгжүүлэхээр заасан. Үүний дагуу хоёр яамны холбогдох, албан тушаалтан, харьяа байгууллагын төлөөллийг оролцуулан дээрх журмуудын төслийг боловсруулах ажлын хэсгийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 9	11-12	

					дүгээр сарын 27-ны өдрийн А/79 тоот тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн зүгээс “Ахмад настанд цогц үнэлгээ хийх, үйлчилгээ үзүүлэх журам”, “Ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний мэргэжлийн удирдлагаар хангах журам”, Ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний мэргэжлийн удирдлагаар хангах журам -ын төслийг хамтран боловсруулж, яамны удирдлагуудад танилцуулж, Монголын ахмадын холбооны саналыг авч тусган 2024.11.29-ний өдрийн 01/1497 тоот албан бичгээр Эрүүл мэндийн яаманд хүргүүлэв. Эрүүл мэндийн яамны удирдлагуудтай 2024.12.10-ны өдөр уулзалт хийж журмыг яаралтай батлуулахаар шийдвэрлэсэн.		
6.	Арга хэмжээ 1.6. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээний шинэчлэн батлуулна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн журмуудыг боловсруулж,	100%	0%	100%	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх аргачлал, заавар, үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, үйлчилгээ үзүүлэх журам, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хийх гэрээний загвар, үнэ тарифын журмын төслийг боловсруулав. Журамд санал авахаар харьяа ХХҮЕГ, 21 аймаг, 9 дүүргийн Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ хариуцдаг албан хаагчид, халамжийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагууд, багш судлаачдыг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулав. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх иргэн, аж	10-12	

[illegible]

1.	Арга хэмжээ 2.1. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх тооцоо болон Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар батлуулахад бэлтгэх	100%	0%	100%	Нийгмийн халамжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт “Нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээг тухайн үед мөрдөж байгаа хүн амын амьжиргааны доод түвшингийн хэмжээг үндэслэн Засгийн газар тогтооно.” гэж заасан. Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэхэд зориулж 119.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг нэмж батлуулахаар тусгасан. Иймд хүн амын амьжиргааны доод түвшний өсөлт болон УИХ-д өргөн мэдүүлсэн төсөвтэй уялдуулан халамжийн тэтгэврийг 6 хувь, асаргааны тэтгэмжийг 6 хувиар тус тус нэмэгдүүлэхээр Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, тооцооллыг боловсруулсан. 2025 оны төсвийн төсөл УИХ-аар эцэслэн батлагдсан дараа батлагдсан төсөвт багтаан дахин хянаж, Засгийн газрын хуралдаанаар батлуулахад бэлтгэсэн.	10-12	
----	--	------	----	------	---	-------	--

--	--	--	--	--	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Төрийн албан хаагчийг шатлан дэвшүүлэх мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах	100%	0%	100%	Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, сертификат авсан.	07-12	
2.	Арга хэмжээ 2 Мэргэжил дээшлүүлэх олон улсын сургалтад хамрагдах	100%	0%	100%	Нэгдсэн үндэстний байгууллагын нийгэм, эдийн засгийн комиссын хуралд оролцож, салбар хуралдаанд Монгол Улсын нийгмийн хамгааллын асуудлаар 2 илтгэл тавьж, бусад улсын туршлагыг судалж, ном мэдээлэл цуглуулж танилцав. Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсад зохион байгуулсан олон улсын хуралд оролцож, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ, ядуу өрхөд чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чиглэлээр Филиппин, Индонез, Пакистан зэрэг улсын туршлагаас суралцав.	10-12	
3.	Арга хэмжээ 3. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр бусад улсын хууль, тайлан, туршлага судлах	100%	0%	100%	Нийгмийн халамжийн хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан дэлхийн улс орнуудын туршлагыг судалсан. Тухайлбал, Франц, Бельги, Австри зэрэг дэлхийн өндөр хөгжилтэй орнууд хүүхдийн тоо, эцэг эхийн орлогоос хамаарч тэтгэмж, тусламж олгох, олон хүүхэдтэй гэр бүлд татварын хөнгөлөлт	10-12	

					үзүүлэх, орон сууцтай болох, өрхийн аж ахуйтай болоход нь хөнгөлөлттэй зээл өгөх арга хэмжээг судалсан.		
--	--	--	--	--	---	--	--


Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) "Нийгмийн хамгааллын үндэсний тогтолцооны концепци загвар боловсруулах" ажлын хэсэгт ажиллав.	100%	0%	100%	"Нийгмийн хамгааллын үндэсний тогтолцооны концепци загвар боловсруулах" ажлын хэсэгт долоо хоногийн Мягмар, Пүрэв гарагт ажиллаж Нийгмийн халамжийн салбарын зорилго, зорилт, тогтолцоог тодорхойлох, хэв шинжийг ялгах, зарчмыг тодорхойлох зэрэг ажлыг хийж гүйцэтгэв.	10-12	

ТАЙЛАН ГАРГАСАН:

Нийгмийн халамжийн хэлтсийн
даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч
(Албан тушаал)

Ю.Отгонбилэг /



2024.12.10

(Нэр, гарын үсэг)

(Огноо)